

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**
(2022 оны эхний хагас жилийн байдлаар)

2022.06.16

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд хүрсэн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2, 6.2.3-т заасан аргачлалыг удирдлага болгов.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын 2 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний засаглалын бодлого бүлэгт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, хүрэх түвшингийн үр дүнгийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дундаж үнэлгээ **“Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 80.0 хувьтай** байна.

ТӨБЗГ нь хариуцан хэрэгжүүлэх 1 арга хэмжээ (МУТЖҮЧ - 5.1.1, ЗГҮАХ – 4.4.10, МУЖХТ – 4.1.19), 1 арга хэмжээ (МУТЖҮЧ – 5.1.1, ЗГҮАХ – 4.4.10, МУЖХТ - 4.4.1.)-ний хамтран хэрэгжүүлэгч (ХЗДХЯ) байгууллагаар үүрэг хүлээсэн.

4.1.19. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээний хүрээнд зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг дараах байдлаар төлөвлөсөн. **Үр дүн – 90.0 хувь:**

- **Хууль батлагдсан байна:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдаж, Засгийн газрын 05 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанд хэлэлцүүлэгдэн, хуралдаанаас хуулийн төсөлд зарчмын зөрүүтэй санал гарсан тул дэмжихээс татгалзаж хойшлуулсан, Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг ХЗДХЯ-аас боловсруулж, УИХ-ын 06 дугаар сарын 09-10-ны өдрийн нэгдсэн чуулганаар Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх эсэхийг хэлэлцээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэрлэсэн;
- **3 журмын төслийг баталж мөрдүүлсэн байна:** Хуулийн төсөл одоогоор батлагдаагүй тул дагалдан гарах дүрэм, журам батлагдаагүй болно;
- **Компанийн засаглалын дундаж үнэлгээ 65-70 хувьд хүрсэн байна:** УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолоор төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг баталсан. Уг үндсэн чиглэлийн хүрээнд төрийн өмчит хуулийн этгээдийг олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах зорилгоор төрийн өмчит нэр бүхий 25 компанийн 34 хүртэлх хувийн хувьцааг, Төрийн банкны нийт хувьцааны 20 хүртэлх хувийг тус тус нээлттэй

арилжихаар шийдвэрлэсэн. 2022 оны компанийн засаглалын үнэлгээ **69.0 хувьтай** байна.

4.4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэл хийж, хяналт тавих арга хэмжээний хүрээнд зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг дараах байдлаар төлөвлөсөн. **Үр дүн – 70.0 хувь:**

- **Улсын үзлэг, тооллого зохион байгуулсан байна:** Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг эхлүүлж, ТӨБЗГ-ын даргын 2022 оны Б/20 дугаар тушаалаар нийслэл, 21 аймагт холбогдох арга зүйн сургалт, семинарыг зохион байгуулж, удирдамжаар ханган ажиллаж байна. ТӨБЗГ-ын Ажлын хэсгээс 2022 оны 4 болон 5 дугаар сард нийслэл, 21 аймагт ажиллаж, улсын үзлэг, тооллогод хамрагдах байгууллагын холбогдох албан хаагчдад уг ажилд ашиглагдах програм хангамжийн болон тооллогын арга зүйн сургалтыг хийсэн. Улсын үзлэг тооллогыг зохион байгуулахад шаардлагатай нийт 301.0 сая төгрөгийн төсөв 2022 оны улсын төсөвт тусгагдан батлагдсан. Astvision ХХК-тай хамтарч улсын үзлэг, тооллого, өмчийн бүртгэлийн програм хангамжийг хөгжүүлж, туршин ашиглаж байна.

Гурав. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал /Зөвлөмж/

- Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хүрэх түвшингийн гол үр дүнг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хоёр мянган (2000) тэмдэгтэд багтаан тайлагнаж байх;
- 2022 оны жилийн эцсийн байдлаар дээрх 2 арга хэмжээг төлөвлөгдсөн зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд бүрэн хэрэгжүүлэх.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА **Б.ЦЭНГЭЛ**

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА **Н.ГАНБОЛД**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛГЭН **Д.ЦЭРЭНЛХАМ**